

# ХҮНГҮЙ НИСЭХ ТӨХӨӨРӨМЖИЙН НИЙТЛЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ БОЛОВСРУУЛАХ ХАМТАРСАН БАЙГУУЛГА /JARUS/-ЫН АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТЫН ТАЙЛАН.

2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр

## 1. Хурлын танилцуулга





Хүнгүй нисэх төхөөрөмжийн нийтлэг хууль тогтоомжийг боловсруулах хамтарсан байгуулга /JARUS/-ын анхдугаар чуулга уулзалт нь Бүгд Найрамдах Казахстан Улсын нийслэл Астана хотод 2024 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 17-ны өдрийн хооронд зохион байгуулагдлаа.

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/270 дугаар тушаал, батлагдсан удирдамжийн дагуу Аюулгүй ажиллагааны дотоод хяналт, дүрмийн боловсруулалтын албаны дарга С.Ерханат, Иргэний нисэхийн үнэдсэний төвийн Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны агаарын зайн мэргэжилтэн С.Бат-Эрдэнэ нар уг чуулга уулзалтад оролцов.

Энэхүү хуралд Армени, Швейцарь, Гүрж, Австрали, ОХУ, АНУ, Испани, Польш, Киргиз, Их Британи, Словак, Япон, Итали, БНХАУ, ХБНГУ, Өмнөд Африк, Франц, Гана, Румын зэрэг улсын Иргэний нисэхийн байгууллага, мөн агаарын навигацийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөгчид оролцож, хүнгүй нисэх төхөөрөмжийн эрх зүйн орчныг бүрдүүлэхэд нийт дөрвөн ажлын хэсэгт хуваагдаж, чиглэл тус бүрт нэгдсэн дүгнэлт гарган ажилласан.

## 2. Хурлаар хэлэлцсэн асуудлууд

- SORA 2.5 хувилбар: JARUS-ын хаврын чуулганы уулзалтаар SORA 2.5 хувилбарыг гаргаж, шинэ ажлын хөтөлбөрийг танилцуулсан.
- WG OPS ORG & PERS: Ажлын хэсгийн ахлагч Зиа Мээр зайнаас удирддаг нисгэгчийн ур чадварын шаардлага (RPC) болон Category B үйл ажиллагааны үнэлгээний талаар танилцуулсан. Ажлын хэсэг нь SORA Annex A, A3-д нийцүүлэн үйл ажиллагааны гарын авлагын загвар болон дэмжих удирдамж боловсруулж байна.
- WG AW: Ажлын хэсгийн ахлагч Маркус Фарнер нь CS-HAPS болон CS-UAS, өндөр нарийвчлалтай системийн (HCS) Annex C, EASA болон FAA-ийн дүрмийг ICAO-гийн зохицуулалттай хэрхэн нийцүүлэх талаар болон ажлын хэсгийн ажлын тайланг танилцуулсан.
- WG SRM: Ажлын хэсгийн ахлагч Ёорг Диттрич SORA 2.5 багцын шинэчлэл болон SORA 3.0 ажлын төлөвлөгөөг танилцуулсан.
- WG AUTO CONOPS: Ажлын хэсгийн ахлагч Крейг Блоч-Хансэй ХНТ үйл ажиллагааны автоматжуулалтын үнэлгээний арга зүй болон агаарын орон зайн дах автоматжуулалтын талаар JARUS вэбсайт дээр нийтлэгдсэн төслийг танилцуулсан.



### 3. Чуулга уулзалтын үр дүн

Энэ удаагийн чуулга уулзалтад Бүгд Найрамдах Армени Улс, Бүгд Найрамдах Киргиз улс нь гишүүнчлэлээр орсон бөгөөд Монгол Улс нь JARUS-д нэгдэн орсон 69 дэх улс болж гишүүнчлэлийн баримт бичгээ хүлээж авлаа.

JARUS байгууллагын нарийн бичгийн дарга Prof.Лиу Хао гишүүнчлэлийн батламжийн захидлуудад гарын үсэг зурж, шинээр элсэн орж буй эдгээр гурван улсын төлөөлөгчдөд гардуулж, хүнгүй нисэх төхөөрөмжийн эрх зүй, баримт бичгийг боловсронгуй болгох үйл ажиллагаанд хамтарч ажиллахаа илэрхийллээ.

Мөн ACI болон JARUS байгууллагууд цаашид хамтран ажиллах санамж бичиг байгуулж, ACI-ийн ерөнхий захирал Luis Felipe de Oliveira болон JARUS-ын дарга Giovanni Di Antonio нар гарын үсэг зурж, соёрхон батлав. Энэхүү санамж бичгээр хүнгүй нисэх төхөөрөмж болон дэвшилтэт агаарын хөдөлгөөнд зориулсан вертикал нисэх буудал болон хүнгүй нисэх төхөөрөмжийг иргэний нисэхийн салбарт аюулгүй, үр ашигтай байдлаар ашиглах, цаашдын тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлээр хамтран ажиллахаа илэрхийлэв.

### 4. Цаашид авах арга хэмжээ

- Хүнгүй нисэх төхөөрөмжийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, үндэсний баримт бичиг, тэдгээрийн нэмэлт өөрчлөлтийн тухай мэдээллийг JARUS-д хүргүүлэх, мөн уг байгууллагаас зохих стандарт баримт бичгийг авах, нутагшуулах зэргээр хамтын ажиллагааг сайжруулах;

- JARUS байгууллагатай хамтран ажиллахаар томилогдсон төлөөлөгч /Focal point/-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг, эсхүл багийн зохицуулалтыг бүрдүүлэх;
- Монгол Улсад хүнгүй нисэх төхөөрөмжийн ашиглалт, тэдгээрийн аюулгүй, үр ашигтай, хүртээмжтэй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээний төлөвлөгөө гаргах, биелэлтийг хангах;
- Хүнгүй нисэх төхөөрөмжийн нийтлэг хууль тогтоомжийг боловсруулах хамтарсан байгуулга /JARUS/-ын болон бусад олон улсын арга хэмжээнд идэвхтэй оролцох.

ТАНИЛЦСАН:

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН  
ДАРГА



Б.БАТБАЯР

ТАЙЛАН БИЧСЭН:

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДУГААР ХЯНАЛТИ,  
ДҮРМИЙН БОЛОВСРУУЛАЛТЫН  
АЛБАНЫ ДАРГА



С.ЕРХАНАТ

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБАНЫ  
АГААРЫН ЗАЙН МЭРГЭЖИЛТЭН



С.БАТ-ЭРДЭНЭ